

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Мижид	Дугаар	L169
Оршин суугаа аймаг	Сэлэнгэ	Оршин суугаа сум	Мандал
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Орхироогийн хийд, Өлөнтийн дуган, Хэрхийн дуган	Сүм хийдийн дугаар	СЭМН 031, СЭМН 028, СЭМН 003
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 17	Ярилцлага авсан хүн	Мөнхнасан



Сэлэнгэ аймгийн Мандал сумын Орхироогийн хийд, Өлөнтийн дуган, Хэрхийн дуган

2007 оны 7 сарын 17-ны өдөр. Судалгааны баг Сэлэнгэ аймгийн Мандал сумын 2-р багийн иргэн, өндөр настан Мижид гуайтай уулзаад байна. Тус сумын нутаг дэвсгэр дээр байсан **Орхироогийн** хийдийн тухай ярилцлага авах гэж байна.

Асуулт:-Та **Орхироогийн** хийдийн тухай ярьж өгөхгүй юу.

Хариулт:-Манай **Орхироо** гэдэг бол 100 шахуу өрхтэй, дээр үед отог гэж байлаа.Тийм байсан, тэнд байгуулагдсан. Нарийн булаг гээд урдаа нэг рашаантай. Хойноо хоёр хошуутай. Ийм дуган 10 гаруй ламтайгаар байгуулж байлаа. Миний эцэг халзан Гүржав гэдэг хүн эндхийн унзад, хуралд нь **яхав** би хүүхэд байлаа. Явж очиж хэдэн дуган дээр хурал хурахад зун очно, өвөл бас цагаан сараар зарим нэрийг нь мартчихаж, цагаан сарын битүүнд хурдаг хурлыг чинь юу гэдэг билээ. **Тэрнийг** хурж байсан. Тэрний дээд лам Пунцаг гэлэн гэдэг

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хүн цорж нь жинхэнэ дарга нь ухааны хүн байсан. Тэр хэлмэгдэлд яваад өгсөн. Манай аав харин үлдчихсэн юм байна лээ.

Асуулт:-Унзад нь байсан юм байна тийм ээ?

Хариулт:-Тийм

Асуулт:-Цорж лам нь хэлмэгдэлд яваад байхгүй болсон уу?

Хариулт:-Тийм. Пунцаг гэж байлаа. Ингээд хэдэн онд **байхнав**, би л бага сургуульд орох гэж байсан юм даг. Тэнд сахил авч лам болоод, аваад 2, 3 хоног уу, үгүй юу, Мандал сумаас шинэ үсэг заана, монгол ном заана, энэ ном хэрэггүй гэж тэгээд эргээд монгол номоо үзэж заалгаж байлаа. Ингээд Төвд номыг би үзэж сураагүй. Дөнгөж ороод л манайхны настай, залуучууд тоглодог байсан юм, энэ золиг л энэ хурал гарснаас хойш дуган устах нь байна.

Асуулт:-Тэр хийдийн гол шүтээн нь ямар бурхан байсан юм бол?

Хариулт:-Гол шүтээнийг нь чухам нэрийг нь мэдэхгүй байна. Манайхан л таван хаан гэдгийг шүтдэг, адуу доргоны махыг хүндэтгэж иддэггүй ийм айл байлаа. Миний ах нэг хүн байсан юм. Тэр бол хотод лам байсан. Манайх жалга болгон дугантай байсан, энэ хурлаа хураад гол төлөв нь алга болсон доо. Хэдэн онд **байхнав** тэр чинь дуусаад дараагаар нь дуганыг маань буулгаад аваад явсан.

Асуулт:-Хааш нь авч явсан юм бол?

Хариулт:-Орос цэргүүд ирээд аччихсан, 17, 18 машин болсон юм даг.

Асуулт:-Бурхан тахил бүх юмтай нь бүгдийг нь аваад явчихсан уу?

Хариулт:-Бурханыг нь овоолоод шатаачихсан. Сүүрин дээр нь.

Асуулт:-Байшин нь ямар юмаар хийсэн юм бол?

Хариулт:-Дүнзэн модоор хийсэн байсан. Гоё будгаар будаад, багана нь бол маягтай сайхан. Ер нь хэрдээ **под** хийсэн дуган байсан.

Асуулт:-Хэдэн онд үүсгэж байгуулагдсан юм бол тэр дуган?

Хариулт:-Миний энэ яриад байгаа чинь хэдэн он **байхав**, 25-тай хүн 7, 8-тай байна гэдэг чинь.

Асуулт:-25 онд төрсөн хүн 7, 8 настай байна гэж үү?

Хариулт:-Тийм.

Асуулт:-32 онд л 7 настай байна даа.

Хариулт:-Тэгэх нь. 30 хэдэн оны үеийг би яриад байгаа юм. 32 оноос урд байгуулагдсан юм байна. 25 оноос урд байгуулагдсан байгаа юм.

Асуулт:-10 орчим ламтай хурал номоо хурдаг байсан?

Хариулт:-Тийм. **Хэрхийн** дуган гэж энд нэлээн том дуган байсан. Тэгээд үе үеийн хурал болоход Хэрх, **Орхиороо**, **Сэвсүүлийнхний** дуганы лам нар очиж их л өргөн хурал болж байгаа юм ярьдаг байлаа.

Асуулт:-**Орхиороогийн** дуганы лам нар ямар уул хангайгаа дахидаг байсан юм бол?

Хариулт:-Мандал гэж энэ хойд уулыг. **Тэрүүгээрээ** сумаа нэрлэсэн. Энийг л их тахина даа.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Асуулт:-Жилд 1 л удаа тахих уу? хэдэн удаа тахих вэ?

Хариулт:-Нэг л удаа тахина, голдуу.

Асуулт:-Зун тахих уу, хавар тахих уу?

Хариулт:-Зун тахина. Зуны эхэн сард тахидаг бололтой юм билээ.

Асуулт:-Цагаан идээ, сүү таргаараа тахичих уу?

Хариулт:-Бас шүүс гаргана. Орой дээр нь гарна. Тэгээд хүүхэд мод чулуу хугалж болохгүй, жигтэйхэн айхтар юм ярьж ярьж цагираг татуулж, идэж овоо тахихыг үзнэ дээ.

Асуулт:-Морь **маланд** идээ, цагаа, шүүсээ ачаад гараад явчих уу?

Хариулт:-Тэгнэ. **Хэнгэрэгээ** бариад ачаад л. Бөх, морь гэдэг юм байгаагүй. Зүгээр **тахичихаад**. Мандал гээд айхтар уул түймэр гарахад бороо ордог, шаггүй уул гэж ярьдаг байлаа. Манай **Орхироогийн** дуганы урд нэг овоо байдаг юм. Тэрнийг хүүхдийн овоо гэж. Хүүхдийг тэнд баярлуулж наадмын үед, зуслангийн үед цэнгүүлдэг нэг овоо байгаа. Зүүн талд нь нэг рашаан байгаа. Энэ рашаанаас очиж авахад аягүй хатуу чанга даа, цагаан идээ хүргэж болохгүй, улаан юм гаргаж болохгүй, лонх шилээ угаа, дороос авна гээд. Тэр өвөл ч хөлдөхгүй, одоо харин муудаад байгаа юм. Тэрний эхэн дээр байгуулагдсан дуган даа. Дуганы хойно нэг хөшөө байдаг юм, Мандалын ард нь нэг хөшөө байдаг юм. Энэ хоёр хоорондоо гүйдэлтэй, айл хунар дунд нь бууж болохгүй гээд л бидний тэнхим сурталчилна даа. Яг нүдээрээ үзээд тийм юм мэдэхгүй байна.

Асуулт:-**Орхироогийн** дуганыг орос цэргүүд аваад явсан гэсэн шүү дээ, ачаад. Тэрний дараа бүх лам нарыг нь бариад явчихсан уу, аль эсвэл?

Хариулт:-Бараг бүгдийг нь барьсан. Зарим нь хүрч чаддаг ч лам байлаа, их настай нэг нь Мандал дээр очоод ядарсан гэж дуулдсан. Ер нь **залуунууд** нь үлдсэн дээ, муусайн тааруу лам нар нь, жаахан мяндаг тушаалтай, үнзад, ловон эд нарыг нь аваад явсан. Манай аав чинь гэр бүлтэй, малтай, тэгээд тэнд лам их цөөтэй болохоор үнзад хийж байсан юм байгаа биз.

Асуулт:-**Өлөнтийн** дуганы талаар ярьж өгөхгүй юу?

Хариулт:-**Өлөнтийн** дуганыг тун сайн мэдэхгүй. Чойдорж гэдэг цорж ламтай дуган байдаг юм гэнэ лээ гэж хүмүүс ярьдаг байсан. Мөн нэг жижигхэн, бас л 10 гаруй ламтай дуганы тохой гэдэгт байдаг байсан. Хойдох Баянцогт гэдэг уулаа тахидаг. Дээр үед жалга болгон дугантай, айл болгон гэлэнтэй байлаа шүү дээ. **Өлөнтийн** дуганы ламыг мэдэхгүй.

Асуулт:-Чойдорж гэдэг хүн хамба лам нь байсан юмуу?

Хариулт:-Тийм. Тэгээд баригдаад явсан. 32 онд чинь барагтай бүгд лам нар баригдлаа шүү дээ.

Асуулт:-Баянцогтын хайрханаа тахидаг байсан юм байна тиймээ, **Өлөнтийн** лам нар.

Хариулт:-Тийм, арын том уул.

Асуулт:-**Өлөнтийн** дуган юугаар барьсан байсан юм бол?

Хариулт:-Дандаа модоор барина шүү.

Асуулт:-Хужаа нар барьсан уу?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хариулт:-Дандаа хужаа нар барьдаг байсан. Шашны юм өөрсдийнхөө баг орон нутагт дугантай больё гээд Богдод хүсэлтээ тавихаар л Амгалан дээр Хятадын амбан хаан ноён байна. Тэр олон мужаан нартай тэгээд л гэрээ хийгээд жалга болгонд л дуган, тэгээд л амархан **барьчихаж** байгаа юм шүү дээ. Монгол өөрсдөө барьж чадахгүй л дээ. Дандаа хятадууд барьдаг байсан.

Асуулт:-**Сэвсүүлтийн** дуган гэж хаана байсан юм бэ?

Хариулт:-**Сэвсүүлтийн** дуган ингээд **Орхиороо**, **Өлөнт**, **Сэвсүүлт** гэдэг юм.

Асуулт:-**Сэвсүүлийг** хэр мэдэх вэ?

Хариулт:-**Сэвсүүлийг** бүр мэдэхгүй. Дуган л байх нь байсан даг.